



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

САЛБАРЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ГҮЙЦЭТГЭСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Хамарсан хугацаа: 2025 оны эхний хагас жил
ХШҮДАГ-2025-/ДА/05

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт салбарын харьяа 484 байгууллагын хэмжээнд байршуулах мэдээллийн 93.8 хувийг мэдээлсэн дүнтэй. Үүнээс

Харьяа 28 байгууллага 87.8 хувь, Спортын салбарын 32 байгууллага 87.0 хувь, Орон нутгийн 424 байгууллага 94.8 хувийг мэдээлсэн.

Дотоод аудитын дүнгээр салбарын харьяа байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг 1931 удаа хугацаа хоцроож, 49.7 тэрбум төгрөгийн 3030 удаагийн мэдээллийг мэдээлээгүй алдаа дутагдал гаргасан тул цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар сайжирсан, хугацаа хоцроосон мэдээлэл 482-оор буурсан, мэдээлээгүй мэдээллийн тоо 2027-оор буурсан хэдий ч илэрсэн зөрчил 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Танилцуулга	3
Аудитын зорилго, хэрэгжүүлэх цар хүрээ ба арга	3
Аудитын зорилго	3
Аудитын цар хүрээ	3
Аудит гүйцэтгэсэн арга зүй.....	3
Аудитын үр дүн.....	4
Илэрсэн асуудал 3.1	6
Илэрсэн асуудал 3.2	7
Илэрсэн асуудал 3.3	8
Төсвийн ерөнхийлөн захирагч болон яамны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн:	9
Аудитын тайлан, дүнгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн:	10
Дүгнэлт	10
Санал, зөвлөмж.....	10

Танилцуулга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 06 дугаар 23-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс ажлын 20 хоногт Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэн тайланг танилцуулж байна.

Аудитын зорилго, хэрэгжүүлэх цар хүрээ ба арга

Аудитын зорилго

Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ТЕЗ бөгөөд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцад хамрах 484 төсөвт байгууллагуудын Шилэн дансны тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн батлагдсан журмын хэрэгжилтэд дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Аудитын цар хүрээ

Хугацаа: 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа

Аудитад хамрагдах объект нэгж: Салбарын харьяа төсөвт байгууллага-484

Аудит гүйцэтгэсэн арга зүй

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны “Төсөв ба гүйцэтгэл”, “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “Бусад” гэсэн цэсэд оруулсан мэдээллийг хууль, журам зааврын дагуу үнэн зөв, бодитой, иж бүрэн, хуулийн хугацаанд оруулсан эсэхэд үнэлгээ өгсөн болно.

Яамны ХШҮДАГ-аас яам болон түүний шууд харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөд хяналт шалгалт хийж, байгууллага бүрд “Дотоод хяналт шалгалтын тайлан”-г хүргүүлсэн, аудитаар илэрсэн алдаа дутагдлыг хугацаа өгч залруулах арга хэмжээ авч ажиллав. Мөн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэх дотоод аудитын удирдамжийг аймгийн төсвийн мэргэжилтэн нарт танилцуулах сургалтыг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж аудитын гүйцэтгэх, тайлагнах, үр дүнг тооцох талаар арга зүйн зөвлөгөөг өгсөн.

Аймгийн Соёл, урлагийн газрын төсвийн мэргэжилтэн нар орон нутгийн харьяа нэгж байгууллагуудын шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөд хяналт шалгалт хийж, тайланг хүргүүлэн, аудитаар илэрсэн алдаа дутагдлыг хугацаа өгч залруулах арга хэмжээ авч ажиллалаа. Мөн аймгийн хэмжээнд нэгтгэсэн тайланг бичиж албан бичгээр хавсралт маягтын дагуу хавсаргаж ирүүлсэн болно.

Харьяа төсөвт байгууллагуудын тайлант хугацаанд хамаарах шилэн дансанд байршуулсан мэдээллийг төрийн сангийн дансны хуулга, удирдлагын гаргасан хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй тулган шалгаж, нэмэлт тайлбар тодруулга мэдээллийг байгууллагын нягтлан бодогч, холбогдох бусад албан хаагчдаас авч дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг ашиглалаа.

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;

- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт;
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”;
- Сангийн яамнаас гаргасан “Шилэн дансны маягт бөглөх зааварчилгаа”,

Аудитын үр дүн

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт салбарын харьяа 484 байгууллагад 93.8 хувьтай байна

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцад хамаарах салбарын 484 төсөвт байгууллагын Шилэн дансны цахим хуудасны мэдээлэлд нийцлийн аудитыг хийхэд:

- Төвийн шууд харьяа 28 байгууллага 51 талбарт хугацаа хоцроосон;
- Спортын салбарын 32 байгууллага 71 талбарт хугацаа хоцроосон;
- Орон нутгийн харьяа 424 байгууллага 1809 талбарт хугацаа хоцроосон;
- Мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх шалгуурыг хангаагүй 3097 алдаа дутагдал гаргаж Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байдлыг нягтлахад хэрэгжилт 93.8 хувьтай өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 нэгжээр өссөн дүнтэй дүгнэгдэв.

Хүснэгт №1

Үзүүлэлт	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо	Үүнд:		Шилэн дансны хөтлөлт -ийн хувь	Үнэн зөв, бодитой, иж бүрэн байдлын үнэлгээ		Үүнээс	
		Хугацаандаа	Хугацаа хоцроосон		Илэрсэн алдаа зөрчлийн тоо	Хэрэгжилт-ийн хувь	Запруулсан алдааны тоо	Хэрэгжилтийн эцсийн хувь
Салбарын нэгдсэн дүн	42344	40409	1931	95.4	3097	92.7	489	93.8
Харьяа 28 байгууллага	2349	2298	51	97.8	314	86.6	28	87.8
Спортын салбарын 32 байгууллага	2976	2901	71	97.5	404	86.4	18	87.0
Орон нутгийн 424 байгууллага	37019	35210	1809	95.1	2379	93.6	443	94.8

Шилэн дансны хөтлөлтөд илэрсэн нийтлэг алдаа дутагдалд шинжилгээ хийхэд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг дутуу мэдээлэх,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гүйлгээг мэдээлэхгүй байх,
- Хөрөнгө мөнгө захиран зарцуулсан шийдвэр болох ажил үйлчилгээ худалдан авсан гэрээг мэдээлэхгүй байх,
- Тухай бүр буюу 7 хоногийн дотор мэдээлэх ёстой мэдээллийг хуулийн хугацаанд багтаан мэдээлэхгүй байх асуудал нийтлэг гарч байна.

Салбарын харьяа байгууллагаас дараах 29 байгууллага 16-аас дээш удаа мэдээллийг хугацаа хоцроосон алдаа гаргасан байна.

№	Байгууллагын нэр	Мэдээлэл оруулах давтамжийн тоо	Үүнд:	
			Хугацаандаа	Хугацаа хоцроосон
1	Булган аймгийн Хишиг-Өндөр сумын соёлын төв	88	71	17
2	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын соёлын төв	88	66	22
3	Дорнод аймгийн Чойбалсан сумын Соёлын төв	87	69	18
4	Завхан аймгийн Нөмрөг сумын Соёлын төв	88	72	16
5	Өвөрхангай аймгийн музей	88	71	17
6	Өвөрхангай аймгийн номын сан	88	71	17
7	Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театр	88	67	21
8	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Соёлын төв	88	72	16
9	Өвөрхангай аймгийн Баянгол сумын Соёлын төв	88	70	18
10	Өвөрхангай аймгийн Уянга сумын Соёлын төв	88	65	23
11	Өмнөговь аймгийн Баяндалай сум Соёлын төв	88	69	19
12	Өмнөговь аймгийн аймгийн Баяновоо Соёлын төв	88	72	16
13	Өмнөговь аймгийн Ханбогд соёлын төв	88	71	17
14	Өмнөговь аймгийн Цогтowoо сум Соёлын төв	88	72	16
15	Өмнөговь аймгийн Цогтцэций сум Соёлын төв	88	68	20
16	Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театр	88	69	19
17	Сэлэнгэ аймгийн Рашаант тосгон Соёлын төв	86	68	18
18	Төв аймгийн Баян сумын Соёлын төв	88	71	17
19	Төв аймгийн Баяндэлгэр сумын Соёлын төв	88	72	16
20	Увс аймгийн Өмнөговь сумын Соёлын төв	88	72	16
21	Увс аймгийн Зүүнговь сумын Соёлын төв	88	63	25
22	Увс аймгийн Өндөрхангай сумын Соёлын төв	88	70	18
23	Увс аймгийн Ховд сумын Соёлын төв	88	67	21
24	Увс аймгийн Хяргас сумын Соёлын төв	88	69	19
25	Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Соёлын төв	91	73	18

26	Увс аймгийн Өндөрхангай сумын Соёлын төв	88	70	18
27	Увс аймгийн Ховд сумын Соёлын төв	88	67	21
28	Увс аймгийн Хяргас сумын Соёлын төв	88	69	19
29	Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Соёлын төв	91	73	18

Илэрсэн асуудал 3.1 Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 732 удаагийн, зарлагын 264 удаагийн нийт 30,107.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдлыг шалгахад:

- Харьяа 28 байгууллага 8,085.9 сая төгрөгийн 63 удаагийн орлогын гүйлгээ, 1,153.0 сая төгрөгийн 37 удаагийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.
- Спортын салбарын 32 байгууллага 3,965.8 сая төгрөгийн 102 удаагийн орлогын гүйлгээ, 4,024.5 сая төгрөгийн 93 удаагийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.
- Орон нутгийн 424 төсөвт байгууллагууд 11,780.3 сая төгрөгийн 567 удаагийн орлогын гүйлгээ, 1,098.4 сая төгрөгийн 134 удаагийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Хүснэгт №2

Салбар нэгжийн нэр	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ	Мэдээлбэл зохих гүйлгээ		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		Тоо	Сая төгрөг	Тоо	Сая төгрөг	Тоо	Сая төгрөг
Харьяа 28 байгууллага	орлого	515	50,573.7	452	42,487.8	63	8,085.9
	зарлага	392	10,997.2	355	9,844.2	37	1,153.0
Спортын салбарын 32 байгууллага	орлого	643	23,156.9	541	19,191.1	102	3,965.8
	зарлага	656	16,023.1	563	11,998.6	93	4,024.5
Орон нутгийн 424 байгууллага	орлого	3749	92,549.9	3182	80,769.6	567	11,780.3
	зарлага	1562	19,769.4	1428	18,671.1	134	1,098.4
Нийт	орлого	4907	166,280.5	4175	142,448.4	732	23,832.0
	зарлага	2610	46,789.8	2346	40,513.9	264	6,275.9

Энэ нь мэдээлэх ёстой орлогын гүйлгээний мөнгөн дүнгийн 14.3 хувийг, зарлагын гүйлгээний 13.4 хувийг эзэлж байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 732 удаагийн 23,832.0 сая төгрөгийн, зарлагын 264 удаагийн 6,275.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй алдааг эдийн засгийн орлого, зардлын ангиллаар авч үзвэл: Үүнд:

Орлогын гүйлгээний ангилал:

- Төсвийн санхүүжилтийн орлого -15,681.5 сая төгрөг буюу 65.8 хувь
- Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого – 5,195.4 сая төгрөг буюу 21.8 хувь
- Нэмэлт үйл ажиллагааны орлого -2,597.7 сая төгрөг буюу 10.9 хувь
- Төсвийн дэмжлэг, хандив тусламжийн орлого -357.5 сая төгрөг буюу 1.5 хувь

Зарлагын гүйлгээний ангилал:

- Нэмэлт дансны зарлагын гүйлгээ – 3,056.4 сая төгрөг буюу 48.7 хувийг эзэлж
- Тэтгэмж урамшууллын зардал – 539.7 сая төгрөг буюу 8.6 хувь
- Дулаан, гэрэл цахилгаан, урсгал засварын зардал -2,679.8 сая төгрөг буюу 42.7 хувь

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг хамгийн олон удаа мэдээлээгүй 5 аймгийн дүн

№	Аймгийн нэр	Мэдээлбэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг
1	Архангай аймаг	283	5,071.6	140	2,902.6	143	2,169.0
2	Сэлэнгэ аймаг	162	5768.2	98	3017.1	64	2751.1
3	Төв аймаг	333	6,685.3	271	5,544.0	62	1,141.3
4	Дорнод аймаг	203	4,876.6	155	4,123.5	48	753.1
5	Баян-Өлгий аймаг	163	4,674.7	123	3,882.7	40	792.0

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг хамгийн олон удаа мэдээлээгүй 5 аймгийн дүн

№	Аймгийн нэр	Мэдээлбэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг
1	Увс аймаг	85	811.8	57	710.3	28	101.5
2	Архангай аймаг	75	722.4	49	538.3	26	184.1
3	Говь-Алтай аймаг	101	1,281.3	84	1,124.8	17	156.6
4	Завхан аймаг	80	847.0	69	742.7	11	104.3
5	Хэнтий аймаг	87	1,368.8	80.0	1,229.3	7	139.5

Илэрсэн асуудал 3.2 Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 1253 удаагийн 10,668.2 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зардлын гүйлгээг цахим хуудсанд мэдээлсэн байдлыг шалгахад 10,668.2 сая төгрөгийн 1253 удаагийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь мэдээлэх ёстой гүйлгээний 37.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт №3

Салбар нэгжийн нэр	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт					
	Мэдээлбэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
	Тоо	Сая төгрөг	Тоо	Сая төгрөг	Тоо	Сая төгрөг
Харьяа 28 байгууллага	807	7,265.9	343	4,818.3	464	2,447.6
Спортын салбарын 32 байгууллага	625	8,961.5	265	4,013.5	360	4,948.0
Орон нутгийн 424 байгууллага	1111	12,237.2	682	8,964.6	429	3,272.6
НИЙТ	2543	28,464.6	1290	17,796.4	1253	10,668.2

Таван сая төгрөгөөс доош дүнтэй боловч нэгээс дээш олон удаагийн гүйлгээгээр бүтэн жилдээ 5 сая төгрөг буюу түүнээс дээш дүнтэй худалдан авалтын зардлын гүйлгээг өссөн дүнгээр мэдээлээгүйгээс шалтгаалан алдаа гаргасан байна. Тухайлбал:

- Байрны түрээсийн зардлын 970.8 сая төгрөгийн 56 гүйлгээ,
- Тогтмол зардал, урсгал засварын 3,424.5 сая төгрөгийн 423 гүйлгээ,
- Бараа ажил үйлчилгээ худалдан авсан 6,272.9 сая төгрөгийн 774 гүйлгээг мэдээлээгүй байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гүйлгээг хамгийн олон удаа мэдээлээгүй 5 аймгийн дүн

№	Аймгийн нэр	Мэдээлбэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг
1	Баянхонгор аймаг	210	2,529.9	91	2,054.1	119	475.8
2	Хэнтий аймаг	126	1,404.6	62	885.7	64	518.9
3	Дорноговь аймаг	69	768.5	24	265.4	45	503.1
4	Сүхбаатар аймаг	45	475.0	1	5.7	44	469.4
5	Баян-Өлгий аймаг	87	763.2	46	538.8	41	224.5

Илэрсэн асуудал 3.3 Хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тухай 8,960.0 сая төгрөгийн 1081 тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Салбарын 484 байгууллагын төсвийн шууд захирагчид өөрийн эрх хэмжээний хүрээнд хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тухай 38,238.9 сая төгрөгийн 4251 шийдвэрийг гаргаж, үүнээс шилэн дансны цахим хуудсанд 3170 тушаал шийдвэрийг мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг 74.6 хувиар хангаж ажилласан байна.

Хүснэгт №4

Салбарын нэр	Хөрөнгө мөнгө захиран зарцуулсан тушаал шийдвэр					
	Мэдээлбэл зохих шийдвэр		Мэдээлсэн тушаал шийдвэр		Мэдээлээгүй шийдвэр	
	Тоо	Сая төгрөг	Тоо	Сая төгрөг	Тоо	Сая төгрөг
Харьяа 28 байгууллага	635	14,167.9	404	11,319.1	231	2,848.8
Спортын салбарын 32 байгууллага	1590	11,862.4	1109	7,293.4	481	4,569.0
Орон нутгийн 424 байгууллага	2026	12,208.6	1657	10,666.4	369	1,542.2
НИЙТ	4251	38,238.9	3170	29,278.9	1081	8,960.0

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах үүрэгтэй албан хаагч болон нягтлан бодогчид хууль, тогтоомжийн хугацаа баримтлаагүй, хөрөнгө, мөнгө захиран зарцуулсан тушаал, шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй алдаа дутагдал гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон яамны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн:

ССАЖЗС буюу Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансанд 22 нэр төрлийн мэдээллийг 87 талбарт хуулийн хугацаанд мэдээлэхээс 5 талбарт хугацаа хоцорч мэдээлсэн, 7 хоногийн дотор мэдээлэхээс 64 удаагийн тушаалыг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 8 алдаа гаргасан байна. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 4-р сард оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн. 6-р сард хуулийн хугацаа хоцроосон.
- Хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн.
- Аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн.
- Тайлант хугацаанд хөрөнгө мөнгө захиран зарцуулах тухай 90 удаагийн 7,552.8 сая төгрөгийн тушаал, гэрээг мэдээлсэн боловч 4, 5, 6-р саруудад гарсан 64 удаагийн 5,698.1 сая төгрөгийн тушаалыг тухай бүр буюу долоо хонгийн дотор мэдээлэх хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн.

Дотоод аудитын дүнгээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн 90.8 хувийг бүрэн мэдээлсэн байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад хэрэгжилтийн хувь буурсан үзүүлэлттэй байна.

Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансанд 22 нэр төрлийн мэдээллийг 87 талбарт мэдээлэхээс 2 удаа хугацаа хоцроосон ба мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 12 алдаа гаргасан байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1 удаагийн 9.0 сая төгрөгийн орлогын мэдээг мэдээлээгүй.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын мөнгөн гүйлгээг 4 удаагийн 1,048.4 сая төгрөг хугацаа хоцроосон.
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээг 1 удаагийн 1,002.3 сая төгрөгийг мэдээлээгүй.
- 1-5 сард гарсан тушаалаар ахмадууд мөнгөн урамшуулал олгосон 306.0 сая төгрөгийн тушаалыг мэдээлээгүй.
- 2024 оны Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө оруулсан байна. Хэрэгжилтийн тайланг мэдээлээгүй.

Дотоод аудитын дүнгээр ССАЖЗЯ-ны Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн 86.2 хувийг бүрэн мэдээлсэн дүнтэй, өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын тайлан, дүнгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн:

Орон нутагт албан томилолтоор ажиллаж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээлэл байршуулалттай холбоотой Баян-Өлгий аймгийн харьяа байгууллагуудаас 1,288.4 сая төгрөгийн 120 удаагийн мэдээллийг хоцроосон болон мэдээлэл оруулаагүй зөрчил, Увс аймгийн харьяа байгууллагуудаас 775.97 сая төгрөгийн 131 мэдээллийг хоцроосон болон оруулаагүй зөрчлийг тус тус илрүүллээ.

Шилэн дансны бүртгэл хөтлөлтөд гарсан дээрх 2 аймгийн илэрсэн зөрчлийг газар дээр арилгах арга хэмжээг авч ажиллан 2,064.37 сая төгрөгийн 251 удаагийн мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмжийг өгөн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүллээ.

Харьяа 28 байгууллагаас Хорхорум музей, Дүрслэх урлагийн музей, Чингис хааны өв соёлын хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв, Дуурь бүжгийн эрдмийн театр гэсэн 5 байгууллага, аймгийн СУАЖЗГ-уудаас Сүхбаатар аймгийн СУАЖЗГ дотоод аудитын тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгасан тухай тайлан мэдээг албан бичгээр ирүүлсэн дүнтэй байна.

Аудитын нэгтгэсэн тайлангаар аудитын явцад илэрсэн 3097 алдаа, дутагдлаас 489 алдааг арилгуулах арга хэмжээ авсны дүнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дүн 93.8 хувьтай болж 1.1 нэгжээр өссөн үр дүн гарсан.

Дүгнэлт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт салбарын харьяа 484 байгууллагын хэмжээнд байршуулах мэдээллийн 93.8 хувийг мэдээлсэн дүнтэй.

Дотоод аудитын дүнгээр салбарын харьяа байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг 1931 удаа хугацаа хоцроож, 49.7 тэрбум төгрөгийн 3330 удаагийн мэдээллийг мэдээлээгүй алдаа дутагдал гаргасан тул цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар сайжирсан, хугацаа хоцроосон мэдээлэл 482-оор буурсан, мэдээлээгүй мэдээллийн тоо 2027-оор буурсан хэдий ч илэрсэн зөрчил 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Санал, зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа дутагдлыг арилгаагүй, дотоод аудитын тайлангаар хүргүүлсэн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн албан хаагчдад цаашид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-ийн дагуу сахилгын шийтгэл ногдуулахыг анхааруулж байна.

Аймгийн Соёл, аялал жуулчлал, залуучуудын газрын харьяа байгууллагуудад алдаа, дутагдал илэрвэл тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээнд Төсвийн тухай хуулийн 40.5-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харгалзана” гэсэн заалтын хүрээнд оноо хасна.

Зөвлөмж-1: Харьяа байгууллагын удирдлагад:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлангаар илэрсэн алдаа, цаашид анхаарах асуудлыг тусгасан товч тайлан, зөвлөмжийг байгууллага тус бүрд хүргүүлсэн тул биелэлтийг хангаж хэрэгжилтийн тайланг нотлох баримтын шаардлага хангасан байдлаар 2025 оны 10 дугаар сарын 25-ны дотор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ХШҮДАГ-т ирүүлэх;